



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 дүгээр сарын 29 өдөр

Дугаар 12

Хэрлэн сум

XII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 12 дугаар хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 83,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Мобиком корпораци аймгийн Онцгой комисстой хамтран ажиллах санал танилцуулах

*Мобиком корпораци ХХК Дорнод аймгийн  
салбарын захирал Тунгалагтуул*

2.БНХАУ-ын ӨМӨЗО-оос тусламжаар ирсэн ариутгалын бодисыг ашиглаж болох эсэхийг танилцуулах,

*Мэргэжлийн хяналтын газар*

3.Иргэдийн гэрийн тусгаарлалт ажиглалтын талаар мэдээлэл танилцуулах,

*Аймгийн Засаг даргын орлогч, АОК-ын орлогч дарга Ч.Ганбат*

4.Жолооны сургалтын төвд хяналт шалгалт хийсэн талаар танилцуулах,

*Эрүүл мэндийн газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
орлогч дарга Ч.Ганбат-д:

1.1.Аймгийн Онцгой комисст Мобиком корпорациас хүмүүнлэгийн тусламжаар олгох интернетын модемыг хүлээн авч мэргэжлийн байгууллагуудад хуваарилан шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд олгохыг,

Хоёр.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,

*М* / М.Бадамсүрэн  
*Э.Ганжигүүр* Э.Ганжигүүр

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт:

2.1.Зөвшөөрөгдсөн карго үйлчилгээний тээврийн ариутгалын ажилд шаардлагатай халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас хэрэглэхийг зөвшөөрөв,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа-д:

2.2.БНХАУ-аас ӨМӨЗО-оос хүмүүнлэгийн тусламжаар олгосон ариутгалын бодисны идэвхийг шинжилж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Гурав Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д.

3.2.Эрүүл мэндийн шалтгаан, буяны ажил, карго тээврийн жолооч, хувийн тээврийн хэрэгслээр Улаанбаатар хотоос ирсэн иргэдийн гэрийн тусгаарлалт ажиглалтад хяналт тавих түр журам боловсруулж батлуулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
сумын Засаг дарга нарт:

3.3.Тандалтын давтан шинжилгээ авах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг,

Хэрлэн сумын Засаг дарга, Онцгой комиссын  
гишүүн О.Пүрэв-Очир,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт:



3.4.Хэрлэн суманд тандалтын давтан шинжилгээ авахад гарсан зардал 5,176,599 төгрөгийг Хэрлэн сумын Онцгой комиссын хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр-д:

3.5.Тандалтын давтан шинжилгээ авах 3 тээврийн хэрэгслийг дулаан гражд байрлуулах, өдөр бүр халдваргүйтгэл хийлгэх,бэлтгэл бэлэн байдлыг хангуулахыг,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тархвар судлаач,  
Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг-т:

3.6.Шуурхай штабын хуралдаанд тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн талаар гарсан зөрчил, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар танилцуулж байхыг,

 / М.Бадамсүрэн  
 / Б.Ганганцэцэг

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
орлогч дарга Ч.Ганбат,  
АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

3.7.Зооноз судлалын төвийн өрөө, тасалгаа тус бүрийг угаалтуур, ариун  
цэврийн өрөөтэй болгох зураг төслийг гаргаж танилцуулахыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт:

4.1.Мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүнтэй хяналт, шалгалтын багийн  
дүгнэлтийг үндэслэн халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж "Мөнгөн Хэрлэн",  
"Таны жолоо", "Хөдөлгөөний соёл", "Дорнын жолоо" сургалтын төвүүдийн үйл  
ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН АХМАД Э.ТАНЖИГҮҮР

